

**АЙМАГ, ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР,
ХЭЛТЭС БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 01 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Газар, хэлтэс, харьяа байгууллагууд	Албан даалгаврын биелэлт	ХШҮ
1	АРХАНГАЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u> Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хурууны хээгээр бүртгэх төхөөрөмжийг суурилуулан цалингийн системтэй холбож, гадуур ажлын бүртгэлийн дэвтрийг хөтлүүлэн, ажлын бүтээмж, дэг журмыг сайжруулж байна. ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/31 дүгээр тушаалаар баталсан “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ыг мөрдөн ажиллаж байна. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 15 зорилтот 21 ажлыг хэрэгжүүлэхээр батлаад байна. Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байдлаар тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулан тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай хүргэж байна. 2018 оны 03 сарын байдлаар шилэн дансанд нийт 84 мэдээлэл байршуулсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан сумын мэргэжилтэнд газрын даргын 2018 оны 04 сарын 12-ны өдрийн б/06 дугаар тушаалаар сануулах арга хэмжээг авч, ажил сайжруулах талаар заавар зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас санаачлан зохион байгуулсан “Цэвэр, цэмцгэр, цэцэрлэг хот” аяны нээлт буюу “Нээлттэй хаалганы өдөр” 2018 оны 04 сарын 10-нд зохион байгуулагдлаа. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр тус газраас иргэдэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл өгч, 89 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хариу өгч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд 2018 оны 04 сарын 14-ний өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээний ажилд байгууллагаараа идэвхтэй оролцсон. 2018 онд албан хаагчдыг “Мэргэжлийн харилцааны сургалт”-нд хамруулахаар ХХҮЕГ-т саналаа хүргүүлж, сургалтын захиалгаа өгсөн. 2018 оны 04 сарын 12-ны өдөр Эрүүл мэндийн газар болон “Ар-Мөрөн” чагнуур өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран тус байгууллагын ажилчдын чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт хамруулах, бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авсан. Сорилд нийт 32 ажилтан, албан хаагч 100 % хамрагдлаа.</p>	
2	БАЯН-ӨЛГИЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u> Байгууллагын ёс зүйн хороо байгуулан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид байх талаар зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Иргэдээ сонсьё-төв"-д иргэнээс ирүүлсэн гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг цаг хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. ХХҮГ нь 5 дахь өдөр бүр иргэдтэй уулзалт хийж санал, гомдлын хүлээн авч байна. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай,</p>	

		<p>үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахиулах зорилгоор "Цаг ашиглалт"-ын журмыг шинээр батлан, байгууллагын дотоод журам, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Баяр ёслолын өдрүүдэд Цагдаагийн газар, Онцгой байдлын газартай хамтарч олон нийтийн хариуцлагатай эргүүл томилон ажиллав.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> (тайлан ирээгүй)</p>	
3	БАЯНХОНГОР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлага, хэлтсийн дарга нар 7 хоног бүрийн Лхагва гарагийн өглөөний 08:30-д шуурхай хурал хийж, гүйцэтгэх ажил үүргийн талаар чиглэл өгч, тухай бүр хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны жилийн төлөвлөгөөг баталсан. Цаг бүртгэлийн хурууны хээ унших төхөөрөмжийг байгууллагын И-оффис програмд шилжүүлж, 2 сарын сүүлийн ирцийн дүнг нэгтгэж, байгууллагын дарга, нягтлан бодогчид танилцуулан ажиллаж байна.</p> <p>Ажилтнуудыг ажлын байран дээр нь сургах төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу аймгийн 19 сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Газрын 2018 оны "Ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө", "Ажиллагсдын сургалтын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд 02 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд байгууллагын ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж ажиллалаа.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> (тайлан ирээгүй)</p>	
4	БУЛГАН	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Төрийн албан хаагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор ажилтан нэг бүртэй ёс зүйн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан. 2018 оны 1-р сард ажилдаа хариуцлагагүй хандаж, ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд 5 сарын хугацаатай цалингийн 19,9 хувиар суутгах арга хэмжээ авлаа.</p> <p>Ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийг албан хаагчдад хариуцлага хүлээлгэх болон ажил дүгнэх шалгуур үзүүлэлт болгон хариуцлага тооцох механизмыг бүрдүүлж, 2017 оны эцэст үр дүнгийн урамшуулал олгоход харгалзан үзсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2018.02.22-ны өдрийн А/20 дугаар тушаалаар тус газрын "Ёс зүйн дүрэм"-ийг гаргаж, мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>Төрийн бодлого болон байгууллагын чиг үүрэг, зорилтын дагуу ажилтан, албан хаагчид 7 хоног, сар, улирлаар ажлаа төлөвлөн, биелэлтийг тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын 2018 оны 02-р сарын 16-ны өдрийн тушаалаар 2018 оны "Мэдээ тайлангийн хуваарь"-ийг батлан мөрдөж байна. Мөн удирдлагаас өгсөн үүрэг чиглэл, дээд газар болон дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, зөвлөгөө, чиглэлийн хэрэгжилтийг ханган, цаг хугацаанд нь мэдээлэх ажлыг нийт ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусган тогтмол болгосон.</p>	

Байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”-г Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үндэслэн гаргаж, хэрэгжилтийг хангаж байна. Байгууллагын эрсдэлтэй албан тушаал, ажил, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтны судалгааг гаргахад нийт 10 ажилтан, албан хаагч байгаа ба тэдгээрийн тодорхой асуудалд оролцох оролцоог шаардлагатай үед нь хязгаарлах асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж, ажилтны үйл ажиллагаа хууль тогтоомж болон холбогдох дүрэм журамд нийцэж буй эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, хяналт тавих, шийдвэрлэлтийн байдлыг мэдээлдэг цахим хаяг хуудастай болох ажлыг аймгийн Засаг даргын үр дүнгийн гэрээнд оруулан, холбогдох мэргэжилтний үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлж байна.

Төрийн үйлчилгээний “Нэг цэг”-ийн үйлчилгээг тогтвортой ажиллуулж, “Нэг цэг”-ийн үйлчилгээгээр нийт 850 гаруй иргэнд үйлчилсэн. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ **“Угтах үйлчилгээ”**-г нэвтрүүлж, ажилтан, албан хаагч бүр тусгай хуваарийн дагуу иргэдийг угтан авч үйлчлэн, мэдээллийг өгч, албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах чиглэлээр 3 заалт нэмж оруулан, ажилтан албан хаагчдын ёс зүй, харилцаа, ажлын цаг ашиглалтад хөндлөнгийн үнэлгээг 2 удаа хийж, байгууллагын ажилтан, албан хаагчдын хуралд танилцуулсан.

Төр, захиргааны байгууллагын удирдлагууд иргэддээ хийсэн ажлаа тайлагнаж, санал хүсэлтийг сонсдог график тогтолцоог хэвшүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжүүлж, тусгай хуваарийн дагуу хөдөө сумдад улирал бүр ажиллах, “Нээлттэй хаалга”-ны өдрийг жилд 2 удаа зохион байгуулахаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

Ажилтан, албан хаагчдын ажлын байранд мөрдөх “Ажлын байрны дэг журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна.

2018 оны 03-р сарын 18-23-ны өдрүүдэд төрийн үйлчилгээний чанар хүртээмж, цаашид анхаарах санал, дүгнэлтийн талаар нийт 100 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийн, аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Мэргэжилтэн бүр өөрсдийн ажлаа бусаддаа мэдээлэх, сургалт зохион байгуулах, шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актын талаар мэдээлэл хийх ажлыг тогтмолжуулан, байгууллагын ажилтан, албан хаагчдад тухайн 7 хоногт хийсэн ажил болон дээд газрын шийдвэр, цаашид хийх ажлын төлөвлөгөө, байгууллагаас гарч буй шийдвэрүүдийг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч, хэрэгжилтийг хангаж байна. Ажилтан, албан хаагчдыг аймаг, орон нутагт зохион байгуулсан богино хугацааны сургалт семинарт 6 удаа хамруулсан.

Хөдөлмөр халмжийн үйлчилгээний газрын даргын 2018 оны 02-р сарын 08-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг ажиллагсдын саналыг тусган, шинэчлэн боловсруулж баталсан. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг сар бүр дүгнэж, үр чадварын нэмэгдлийг нийт 5 ажилтанд олголоо. Байгууллагууд дотоод удирдлагын ABLE програмыг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж үйлчилгээг цахим сүлжээ ашиглан хурдан шуурхай хүргэх замаар төсвийн урсгал зардлыг бууруулах ажлыг зохион байгуулж байна.

2018 оны 04 дүгээр сарын байдлаар:

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг тогтоон, сахин биелүүлэх зорилгоор нийт 54 ажилтан, албан хаагчидтай “Төрийн албан хаагчийн ёс зүйн гэрээ”, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г

		<p>байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Тусгай удирдамжийн дагуу 2018 оны 04-р сарын 19-27-ны өдрүүдэд хөдөө, орон нутгийн иргэдэд хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээг хүргэх, зөвлөгөө зөвлөмж өгөх, гарсан санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэх, 2018 онд төсөл хөтөлбөрт хамрагдаж төсөл ирүүлсэн иргэдтэй биечлэн уулзах, нөхцөл байдлыг судлах ажлыг зохион байгуулж, одоогоор нийт 5 суманд ажиллаад байна.</p> <p>Нийт ажилтан албан хаагчдыг нэгдсэн нэг хувцастай болгох ажлыг эхлүүлээд байна.</p> <p>“Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”, төлөвлөгөөг боловсруулан баталж, 2018 оны 4-р сарын байдлаар Улаанбаатар хот болон ХХҮЕГ-аас зохион байгуулж буй 3 удаагийн онлайн сургалтанд нийт 23 ажилтан, албан хаагч, аймаг, орон нутгаас зохион байгуулсан сургалтанд 16 ажилтан албан хаагч хамрагдсан.</p> <p>Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг сар бүр дүгнэж, ур чадварын нэмэгдлийг олгож байна.</p>	
5	ГОВЬ-АЛТАЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргаас албан хаагчидтай 2018 оны үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулж, байгууллагын дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцэн баталлаа. Албан хаагчдын ажлын цагийг нарийн чанд баримтлах, тэдгээрт хяналт тавих, гадуур ажлаар явахдаа бүртгүүлэх ажлын дэвтэр нээн ажиллахын зэрэгцээ албан тасалгаанд 5, гадна орчинг харуулсан 2 хяналтын камерыг нийт 3 сая төгрөгөөр суурилуулан, ажилчдын цаг ашиглалтад хяналт тавьж, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд анхаарч байна. Албан хаагчдын ажиллах орчин, техник хэрэгслийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.</p> <p>Албан хаагчдын зэрэг дэвийг ахиулах талаар саналаа аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн ба тухайн жилийн цалинг тогтоохдоо зайлшгүй нэмэгдүүлэх албан хаагчдын шатлалыг нэмэгдүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн биелэлтэд тавих хяналт шалгалтын төлөвлөгөө гаргасан бөгөөд тайланг хагас, бүтэн жилээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт график үзүүлэлтээр, ойлгомжтой байдлаар байршуулан тогтмол мэдээлж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах 23 заалт бүхий төлөвлөгөөг байгууллагын даргын 2018 оны А/11 дүгээр тушаалаар баталж, албан хаагчдыг сар бүр шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж, мэдээлэл хийхээр хуваарилан үр дүнгийн гэрээнд тусгаж, 2 удаа, сургалт мэдээлэл хийгээд байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Тус газрын ажилтан, албан хаагчдын хурлаар байгууллагын дотоод журмыг хэлэлцүүлэн, тэдний санал бодлыг тусгаж шинэчлэн баталсан бөгөөд албан хаагчдын эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тус журамд оруулан мөрдлөг болгож байна.</p>	
6	ГОВЬСҮМБЭР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалаар баталж, 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран газрын нийт албан хаагчдын дунд зохион байгууллаа.</p> <p>ХХҮЕГ-ын даргын баталсан “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн хэрэгжүүлж байна. Шинээр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын талаар</p>	

		<p>иргэдэд сар бүр мэдээлэл, сурталчилгаа хийх өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 500 гаруй иргэдийг оролцуулан, газрын нээлтэй утас 70543519 –аар 2000 гаруй иргэнд мэдээллийг хүргэсэн байна.</p> <p>Сар бүрийн 25-ны өдөр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулздаг өдөртэй болж, уулзалт, сургалтыг 2 удаа зохион давхардсан тоогоор 150 гаруй иргэдийг хамруулсан. Дээрх ажлуудыг зохион байгуулснаар албан хаагчдын талаар ямар нэгэн санал гомдол гараагүй, албан хаагчид ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. Авлигын тухай хуулиар албан хаагчдын дунд сургалт хийж, сургалтыг уламжлалт аргаас ангид аудио, видео хэлбэрийг түлхүү ашиглан зохион байгуулсан. Бусдад давуу тал олгохгүй байх, ах дүү хамаатан садан нь Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээнд хамрагдах тохиолдолд татгалзаж байхыг онцгой анхааруулсан болно.</p> <p>Улирал бүр байгууллагын хурал дээр авилгагүй, хүнд сурталгүй, үнэнч шударга ажиллах талаар андгай уншуулж, гарын үсэг зуруулж хэвшүүлсэн. 2018 оны 02 дугаар сард зохион байгуулагдсан аймгийн харьяалалгүй ахмадын хурал дээр хувийн ашиг сонирхол, авлигаас ангид ажиллаж байгаагаар зарлалаа.</p> <p>Иргэд хуулийн мэдлэг дутмагаас Засгийн газрын 1111 төвд хандах нь ихэссэнтэй холбоотой газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар ном, гарын авлага, шторкыг бэлтгэн орон нутгийн иргэдэд хүргэж, нийт 2 удаагийн өдөрлөгийг НБХэлтсийн харьяа бүх байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 300 гаруй иргэнийг хамрууллаа. Нийт 3 сумын 421 гаруй өрхөөр зочилж нөхцөл байдалтай танилцан, мэргэжилтнүүдэд зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Албан хаагчдыг ажлын 8 цагаар Facebook, twitter зэрэг сошиал сүлжээнд орох боломжийг хааж хязгаарласан. Ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллаж байгаа эсэхэд газрын даргын удирдамжаар хяналтын мэргэжилтэн хяналт тавьж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>ХАБЭА-н сарын аяны хүрээнд Шивээ-Овоо ХХК-ийн албан хаагчдад 2018 оны 4 сарын 18-ны өдөр сургалт зохион байгууллаа.</p> <p>2018 оны 04 сарын 09-ний өдрийн нийт ажилчдын хуралд газрын дарга Д.Гансүх ашиг сонирхлоос ангид байж, үнэнч шударга ажиллах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, хөнгөн шуурхай үзүүлэх талаар нийт ажилчдад мэдээлэл хийж, анхааруулга өгсөн.</p> <p>Аймгийн холбооны газартай хөдөлмөр, халамжийн үйлчилгээг тогтмол хүргэх гэрээг 2018 оны 04 сараас эхлэн хийж, хамтран ажиллаж байна. 4 дүгээр сард сумдад хөдөлмөрийн өдөрлөг хийж, энэ үеэр газрын дарга авлигагүй хамт олон гэдгээ зарлан сурталчилсан ба орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажилласан.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой гарын авлага, эмхэтгэлийг гарган АДЗөвлөлийн гишүүд 27 хүнд болон 200 гаруй иргэдэд тараасан.</p> <p>Ажилчдын ажлын үр дүнг сайжруулах, мэдээллийг жигд, хүртээмжтэй хүргэх зорилгоор 7 хоногийн эхний өдөр шуурхай зөвлөгөөнийг хийж хэвшсэн ба 2018 он гарсаар нийтдээ 11 удаагийн шуурхай зөвлөгөөн хийсэн байна.</p>	
7	ДАРХАН-УУЛ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>2018 онд “Иргэндээ үйлчилдэг төрийн албаны соёлыг төлөвшүүлэх” зорилгын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдэд ёс зүйтэй, зөв боловсон, хөнгөн шуурхай, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх 	

- Сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахиж, цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх
- Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үйлчилгээг цаг хугацаанд чанартай хийж гүйцэтгэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны хөтлөлтийг хуулийн хугацаанд хийн, тогтмол хяналт тавьж, авлигад өртөж болзошгүй, эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний талаарх тандалт судалгааны ажлыг зохион байгуулж байна. Судалгаа, шинжилгээнд үндэслэн авлигад өртөж болзошгүй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргасан бөгөөд тус бүрт нь мэдээлэл өгөх үүднээс 2018 оны 04 дүгээр сард багтаан Авилгатай тэмцэх газрын Дархан-Уул аймаг дахь олон нийт, иргэний зөвлөлийн гишүүдээс сургалт авахаар төлөвлөж байна.

Байгууллагын санал хүсэлтийн дэвтэрт 2 гомдол ирснийг шийдвэрлэж хариу мэдэгдсэн. Дээрх асуудлаар 1 албан хаагчид цалингийн 20 хувь хүртэлх сахилгын шийтгэл ногдуулсан.

Монгол Улсын Засгийн газрын албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, дараах үйл ажиллагааг зохион байгууллаа Үүнд:

- Цаг бүртгэлийг гараар бүртгэдэг байсныг хурууны хээгээр бүртгэдэг багаж тоног төхөөрөмж суурилуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлын цаг бүртгэлийн системийн дагуу сарын цалинг бодож эхэлсэн.
- Цаг ашиглалт, цагийн менежмент сэдвээр 2018 оны 03 дүгээр сарын 05-ны өдөр Дархан-Уул аймгийн ИТХ-ын төлөөлөгч Т.Тулгаатай хамтран сургалт зохион байгуулсан.
- Сум, багийн Хөдөлмөр, эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн болон бусад албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах үүднээс 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн “ABLE Cloud” веб дээр суурилсан програмын үндсэн хэрэглэгчээр нийт ажилтан албан хаагч бүрийг бүртгэсэн. “ABLE Cloud” веб дээр суурилсан програмын үндсэн хэрэглэгчээр бүртгэснээр Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэхэд дэмжлэг болох юм. Мөн сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар өглөө, орой цагаа бүртгүүлэх боломжтой болж байна.

Төрийн бодлогын залгамж чанар, тогтвор суурьшилтай ажиллах бодлогын хүрээнд:

- 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Дархан JCI байгууллагатай хамтран “Ажлын байрны стресс, түүнийг даван туулах арга зам, ажлын байран дээр хэрхэн аз жаргалтай байх вэ?” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.
- Байгууллагын ажилтан, албан хаагчдыг орон сууцжуулах зорилтын хүрээнд аймгийн МСҮТ, Нийгмийн даатгалын газар, Хаан банкттай хамтран 64 айлын орон сууцны барилга барих асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр барилга барих газрын гэрчилгээг газрын дарга С.Энхболдод гардуулж өгсөн бөгөөд 4, 5 дугаар сард барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна.

2018 оны 04 дүгээр сарын байдлаар:

Байгууллагын ёс зүйн хорооны хурлаар хамт олны уур амьсгал, албан хаагчдын ажилдаа хандах хандлагыг сайжруулах талаар хэлэлцэж, ажилтан, албан хаагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх амралтын өрөөг тохижуулж эхлээд байна.

Авлигатай тэмцэх газрын Дархан-Уул аймаг дахь олон нийт, иргэний зөвлөлийн гишүүд болох

		Нарангэрэл, Оюун, Насанбат болон шүүхийн байгууллагаас Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хууль, Авлигын тухай хуулиар сургалт авч, нийт 37 албан хаагч хамрагдсан. Мөн ГХУС зөвлөлөөс Цагдаагийн газартай хамтран гэмт хэрэгт өртөж болзошгүй нөхцөл байдалд хэрхэн асуудлыг шийдвэрлэх вэ сэдвээр сургалт зохион байгуулсан.	
8	ДОРНОД	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХҮГ-ын даргаас албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээнд сахилга хариуцлагын заалтыг тусган ажиллаж байна.</p> <p>ХХҮГ-ын албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, Удирдлагын академийн багш, доктор Р.Бадралмаа “Стратеги төлөвлөлт, баг бүрдүүлэх, багийн харилцаа, хамтын ажиллагаа”, Канадын МЕРИТ төслийн төлөөлөгч Misheel Канад улсын төрийн албаны туршлага, үйл ажиллагаа, аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн ахлах мэргэжилтэн “Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах”, хууль, эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчлэл сэдвээр тус тус төрийн захиргааны 30, сум хариуцсан мэргэжилтнүүд 13, төрийн үйлчилгээний 37 мэргэжилтэн, албан хаагчдад зориулж сургалт явууллаа. Мөн ажлын байран дээрх сургалтын хүрээнд Захиргаа хяналтын хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Нийгмийн халамжийн хэлтсээс 2017 онд хэрэгжсэн үйл ажиллагаа, хоцрогдолтой заалтууд, 2018 онд анхаарах асуудлаар мэдээлэл, аргазүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор цагийн бүртгэлд өдөр тутам хяналт тавьж байна. Мөн ABLE програмаар цаг бүртгэх ажлыг туршин нэвтрүүлэхээр төлөвлөсөн. ХХҮГ-ын албан хаагчдыг чадавхжуулах сургалтаар 65 мэргэжилтэн, албан хаагчдад “Цагийн менежмент” сургалтыг зохион байгуулсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> шинэлэг ажил хийгдээгүй</p>	
9	ДОРНОГОВЬ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр, халамжийн газрын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, салбарын үйлчилгээг иргэд нэг дороос хүртэх боломжийг олгох, үйлчилгээний талаар иргэдийн санал авах зорилгоор сар бүрийн 2 дахь долоо хоногийн 2 дахь өдрийн 14 цагаас “Хөдөлмөр-халамж 222” тайлант өдөрлөгийг амжилттай зохион байгуулж байна. Өдөрлөгийг сар бүр өөр өөр хэлбэрээр зохион байгуулж, 03 дугаар сарын 06-ны өдөр Сайншанд сумын 2-р багийн иргэдийн дунд ажиллалаа. Салбарын шинэчлэгдсэн хууль, тогтоомжийг иргэдэд таниулах, үйлчилгээг газар дээр нь хүргэх, ажил хайгч иргэдэд шинэ ажлын байрны захиалгыг танилцуулах, зуучлах, 2018 онд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл өгөх, санал асуулга авах зэрэг үйл ажиллагаа явагдсан.</p> <p>Байгууллагын 2018 оны дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг баталж, 01 сарын 02-ны өдрөөс эхлэн сумдын мэргэжилтнүүдээс ирүүлж буй нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэргийн бүрдэл болон програмд үечилсэн хяналтыг хийж байна.</p> <p>“Хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн үндэс” хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн нээлтийн арга хэмжээг 03 сарын 20-ны өдөр зохион байгууллаа.</p> <p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ирцэд хяналт тавин ажиллаж байна. 90 минутаас дээш цагийн хоцрогдол гаргасан албан хаагчдын нэг өдрийг хасаж тооцохоор хяналтыг тавьж байна.</p>	

		<p>Байгууллагын 2018 оны сургалтын төлөвлөгөөг баталж, 3 дугаар сард 3 удаа сургалт зохион байгуулсан. Давхардсан тоогоор 42 албан хаагч чадавхижуулах сургалтанд хамрагдлаа.</p> <p>Тус газарт гарсан 10 сул орон тооны захиалгыг ТА-ны салбар зөвлөлд хүргүүлсэн ба үүнээс Дорноговь аймаг дахь төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн ажлын байранд тавигдах болзол шалгуурыг хангасан 5 иргэнийг нөөцөөс нөхөх журмын дагуу томилгоо хийсэн.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> (тайлан ирээгүй)</p>	
10	ДУНДГОВЬ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Байгууллагын ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, газрын нийт ажилтан, албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуулсан. 2018 онд газрын мэргэжилтнүүдийн ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх сургалтын төлөвлөгөө батлан, хэрэгжилтэд “Ёс зүйн хороо” хяналт тавин ажиллаж байна. ХХҮЕГ-аас Улаанбаатар хотод зохион байгуулсан 4 удаагийн сургалтанд 3 мэргэжилтнийг, хууль тогтоомжийн болон дотоодын 15 удаагийн сургалтанд нийт албан хаагчдыг, сумын мэргэжилтнүүдийг чадавхижуулах 1 удаагийн сургалтанд 16 мэргэжилтнийг тус бүр хамруулж ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүллээ. Байгууллагын албан хаагчдад авилгын эсрэг соён гэгээрүүлэх чиглэлээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх тухай” сэдвээр тус тус сургалт зохион байгууллаа.</p> <p>Ажлын бүтээмжийг сайжруулах ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор ажлын байран дээрх зураг авалтыг хийж дараах ажлуудыг зохион байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - Давхар ажил эрхлэх боломжтой ажлын байр, албан тушаалыг судалж, зарим орон тоог нэгтгэх, нэмэгдүүлэх талаар ХХҮЕГ-т санал хүргүүлсний үндсэн дээр бүтэц, орон тоог өөрчлөн батлуулсан. - ХХҮГ-ын даргын тушаалаар ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг байгуулж, нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг дахин шинэчлэн боловсруулж батлав. - Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, ажлын бүтээмжийг сайжрууллаа. <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтад сар бүрийн сүүлийн 7 хоногт байгууллагын дотоод хяналтаас хяналт тавин ажиллаж, ажлын цаг ашиглалтын журмыг албан хаагчид мөрдөж хэвшээд байна.</p>	
11	ЗАВХАН	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>2018 оныг байгууллагын хэмжээнд “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах, хариуцлагын тогтолцоог сайжруулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Бүх ажилтан, албан хаагчидтай “Хариуцлагын гэрээ” үргэлжлүүлэн байгуулсны зэрэгцээ гэрээнд 5 заалт нэмж оруулан, 3 заалтыг нарийвчлан өөрчиллөө.</p> <p>Аймгийн Засаг даргын санаачилгаар нийт төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод “Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зарчим”-ыг дагаж мөрдөх нэмэлт заалт тусган, нийт албан хаагчид энгэрийн тэмдэг зүүж эхэллээ.</p> <p>Нийт албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Дотоод сургалтын жилийн төлөвлөгөө</p>	

		<p>боловсруулан баталж, сар бүр хууль эрх зүй, эрүүл мэнд, харилцаа хандлага гэсэн чиглэлээр 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Ажилтан, албан хаагчдтай 2018 оны Үр дүнгийн гэрээ болон Хариуцлагын гэрээ байгууллаа. Тус гэрээнүүдэд сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр 5 заалтыг тусгай арга хэмжээ болгон орууллаа.</p> <p>Мөн сум орон нутгийн удирдлага, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон ХХҮГ-ын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Гурвалсан гэрээ” байгуулан гарын үсэг зурлаа. Орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүд сар бүр цагийн тооцоогоо Сумын Засаг даргаар баталгаажуулан, хийсэн ажлын тайлангийн хамт ирүүлснээр цалин хөлсийг олгож байгаа нь цаг ашиглалт, сахилга хариуцлагыг дээшлүүлсэн үр дүнтэй ажил боллоо.</p> <p>Албан хаагчид өдөрт хурууны хээгээр цагаа 4 удаа бүртгүүлж, сарын цагийн бүртгэлийн нийт хоцрогдол 8 цагаас дээш бол сахилгын арга хэмжээ авах, чөлөөний заалтуудыг нарийвчлан тусгаж өгсөн нь сахилга хариуцлага дээшлэх арга хэмжээ боллоо. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд бүх албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрууллаа. Энэ арга хэмжээнд эхний ээлжинд 28 албан хаагч хамрагдаж, байгууллагын үйлчилгээний 9 ажилтныг ажлын хувцсаар хангалаа.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд цаг ашиглалтыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр заалтууд шинэчлэн оруулж, хэлэлцэн баталлаа.</p>	
12	ОРХОН	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u> Авилгаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах, үйлчилгээний соёл, ажилтны ёс зүйд онцгой анхаарч байна. Үүнд: МУ-ын ЗГ-ын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ыг үндэслэн газрын дэргэдэх ёс зүйн хорооноос 2018 оныг “Сахилга-хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэх жил” болгон зарласан. Энэ ажлын хүрээнд 2018.01.04-ний өдөр “Нийгмийн ажлын ёс зүй”, “Нийгмийн халамж, үйлчилгээг үзүүлэх ур чадвар” сэдвээр сургалтыг мэргэжлийн багш нартай хамтран зохион байгуулж, газрын бүх ажилтан, ажиллагсдыг хамруулсан.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажилчдын ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор албан хаагч бүрт хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, үйлчилгээний хяналтын тогтолцоог шинэчлэн, алдааны тайлан хөтлөж эхлээд байна.</p> <p>Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа, байрны урьдчилгаа төлбөрийг төлөх боломжтой 7 албан хаагчийн нэрсийг Төрийн банкны ипотекийн 8% зээлд хамруулахаар аймгийн ЗДТГ-т хүсэлт хүргүүлээ. “Өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэх, түүний шийдвэрлэлтэд хяналт тавих” цахим мэдээллийн системтэй болохоор ажиллаж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай тогтоол гарсантай холбогдуулан хэрэгжүүлэх 13 арга хэмжээтэй төлөвлөгөө гаргасан. Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ил тод байдлын төлөвлөгөө” батлагдан гарсан. 2018 онд Төрийн ажил үйлчилгээг сурталчлах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж тэдний</p>	

		<p>санал, хүсэлтийг авах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 3-4 удаа зохион байгуулах хуваарь гаргасан. 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Хөдөлмөрийн өдөрлөг”-ийг зохион байгуулж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг танилцуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх боломж, нөхцөлийн талаар иргэдэд мэдээлэл хийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэд бүтээлийн үзэсгэлэн гаргасан. 460 гаруй иргэн хамрагдаж, 225 иргэн шууд үйлчилгээ авсан байна.</p> <p>И-Оффис систем нэвтрүүлээ. И-Оффис систем нэвтэрснээр газрын удирдлагуудыг мэдээллээр хангах, байгууллагын ажилчид өөрсдийн ажлаа зөв зохион байгуулалттай төлөвлөж, орон зай үл хамааран мэдээллийг шуурхай түргэн солилцохоос гадна албан бичгийн онлайн түгээлт бий болох бөгөөд ингэснээр шийдвэрлэлт нь түргэн шуурхай болж, шуудан холбоо, бичиг цаасны үргүй зардал багасна.</p> <p>Ажилтан бүр ажил хэргээ төлөвлөж хөтөлснөөр газрын нээлттэй ил тод, хүнд сурталгүй, хяналттай болох боломж бүрдэж байна. Газрын дотоод зохион байгуулалт, хоорондын ажлын уялдаа сайжирч ажлын бүтээмж дээшилнэ. Цаг бүртгэлийн болон ажил хэргийн програмууд нь төрийн албан хаагчийн бүтээмжийг ил болгох бөгөөд ажлын ачааллыг тэнцвэржүүлэн сайн ажилтныг зөв тодорхойлж, үр дүнг үнэлэхэд бодит үндэслэл болох юм.</p> <p>Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд дүрэм боловсруулан газрын даргаар батлуулж, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналтын шалгалт хийлээ. Удирдамжийн дагуу үйлчилгээний бүртгэл хөтлөлт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн судалгаа, ажлын байрны эмх цэгц, хувцаслалт, орон нутгийн бодлого шийдвэрийн талаарх мэдлэг, хувийн хэргийн баяжилт, өдөр тутмын тэмдэглэл хөтлөлтийг үзэн шалгаж, даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хүн нэг бүрийн ололт, дутагдлыг нь ярилцан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэхэд тохиолдож болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсрууллаа.</p> <p>Газрын үйл ажиллагаа, хүний нөөц, санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах үүднээс байгууллагын веб хуудсыг шинэчлэн мэдээ, мэдээллийг байрлуулж, урсдаг самбар ажиллуулан, “Угтаж үйлчилье, эелдэг харилцъя” зорилт дэвшүүлж, хөтөч менежер ажиллуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг сан, нийгмийн халамжийн сан, үйл ажиллагааны санхүүгийн тайланг самбарт болон дотоод сүлжээнд тавин, хүний нөөцийг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулалтын зарчмаар авч ажиллуулж байна.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргах, өвчлөлийн зэрэглэлийг тогтоох, өвчин эмгэг эрт илрүүлэх, эрүүл хүний нөөц бүрдүүлэх, зөвлөгөө өгөх зорилготойгоор явуулж дотор, мэдрэл, мэс засал, арьс харшил, чих, хамар, хоолой, нүд, эмэгтэйчүүд, эхо, оношилгоо, артерын даралт хэмжих, зүрх судасны үзлэг хийлгэн, биеийн жингийн индексийг тодорхойлсон. Энэ эрүүл мэндийн үзлэгт 49 ажилтан хамрагдаж, 1,5 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Ажлын туршлагаа харилцан солилцох чиглэлээр “Бусдаас суралцаж, бусдад туршлагаа түгээх” сургалт, уулзалтыг Хөвсгөл, Дархан-Уул, Булган аймгийн ХХҮГ-уудтай тус тус зохион байгуулллаа.</p> <p>Газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан, хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж байна.</p>	
13	ӨМНӨГОВЬ	2018 оны 1 дүгээр улирал	

		<p>Газрын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Үр дүнгийн гэрээ байгуулахад анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 2-р сарын 28-ны өдөр нийт албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газрын ажлын төлөвлөгөөг 2018 оны 02-р сард баталж, хяналт тавин ажиллаж байна. Газрын болон сумдын мэргэжилтэн, албан хаагчдаас “Сахилга хариуцлагын баталгаа” гаргуулан ажиллаж байна. Энэхүү сахилга хариуцлагын баталгаанд авлига, хээл хахуулиас ангид, хүнд сурталгүй ажиллах заалтыг оруулан хэрэгжүүлж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2018 оны 03-р сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Бүтээн байгуулалт-2018” нээлт, төрийн байгууллагуудын “Нэг цэгийн үйлчилгээ” өдөрлөгт оролцож 94 хүнд нийгмийн халамжийн болон холбогдох хуулийн зөвлөгөө өгсөн.</p> <p>2018 оны 03 дугаар сараас цаг бүртгэлийн төхөөрөмжинд ажлаас чөлөөлөгдсөн болон шинээр ажилд орсон албан хаагчдын бүртгэлийн шинэчлэл хийгдсэнээр 22 ажилтны ажлын цаг бүртгэлийг сар бүрийн 20-ноор тасалбар болгон нэгтгэн дүгнэж байна. Мөн газрын ажилтан, албан хаагчдад ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах талаарх үүрэг даалгавар, чиглэлийг газрын болон хэлтсийн шуурхай хурлаар тогтмол өгч биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албаны шалгалт өгсөн 4 албан хаагч 2018 оны 03-р сард төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн. Мөн аймгийн ЗДТГ, ГБХЗХГ-тай хамтран нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслан зэрэг байгууллагад туршлага солилцох арга хэмжээнд оролцсон.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> (тайлан ирээгүй)</p>	
14	ӨВӨРХАНГАЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын номын сангийн номын фондыг 20 номоор баяжуулж, “Номын нөхөр” жилийн аян зарласан. 2018 онд хамгийн их ном уншсан албан хаагчийг шалгаруулан урамшуулахаар шийдвэрлэ эд байна.</p> <p>Албан хаагчдын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах зорилгоор “5s” аяныг эхлүүлээд байна. Аяны хүрээнд “Сайн ангилан ялгах”, “Сайтар цэгцлэн зохион байгуулах”, “Сайхан цэвэрлэж цэмцийлгэх”, “Стандартчилан хэвшүүлэх”, “Сахилга батыг төлөвшүүлэх” гэсэн 5 шалгуурын талаар арга зүйн зөвлөгөө өгч, аяны нэгдсэн удирдамжийг танилцууллаа.</p> <p>Албан хаагчдыг ажилдаа сэтгэл ханамжтай байх, амьдралын зөв дадал хэвшилтэй байхад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эрүүл, зөв хооллолт” сургалтыг зохион байгуулж, 25 албан хаагч хамрагдсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>2018 оны 04 сарын 5,6-ны өдрүүдэд албан хаагчдыг чадавхижуулах сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. 2018 онд албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр шат дараалсан ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд тэдгээрийн нэг нь “Өглөөний цай” арга хэмжээ юм. “Өглөөний цай” арга хэмжээнд аймгийн Гандан пунцаглон хийдийн хамба лам уригдсан бөгөөд албан хаагчдад ажилдаа хэрхэн сэтгэлээсээ хандах, хэрхэн зөв амьдрах талаар мэдээллээр өгсөн болно. Мөн байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор “Хувь хүний хөгжил, үнэ цэнэ”, “Хувь хүний менежмент” зэрэг</p>	

		<p>сургалтыг зохион байгуулсан ба энэхүү сургалт, арга хэмжээ нь ялангуяа залуу албан хаагчдад цаашид хөдөлмөрлөх сэдэл тэмүүлэл, урам зориг өгсөн үр дүнтэй ажил боллоо.</p> <p>Албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, танин мэдэхүйн хүрээг нь нэмэгдүүлэх замаар оюунлаг, мэдлэгжсэн, бүтээлч хамт олныг бий болгон төлөвшүүлэх зорилго тавьж, байгууллагын нийт албан хаагчдын дунд “Бид номын анд” аяныг 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн 8 сарын хугацаатай зарлан ажиллаж байна. Тус аяны нээлтийн үеэр аймгийн төв номын сантай хамтран “Алтан хонх” АХА тэмцээн, “Угийн бичиг хөтлөх” арга зүйн сургалтыг зохион байгуулж, шинээр гарсан ном, хамгийн их уншигчтай номын танилцуулгыг хийж, номын үзэсгэлэн дэлгэлээ.</p> <p>Албан хаагчдын бүтээлч, эерэг сэтгэлгээг хөгжүүлэн илтгэх чадварыг сайжруулах зорилгоор даваа гарагийн өглөөний 8.00 цагт “Өглөөний шуудан” мэдээллийн тогтсон цагтай болсон бөгөөд албан хаагчид хуваарийн дагуу мэдээллээ бэлтгэн танилцуулж эхлээд байна.</p>	
15	СҮХБААТАР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>2018 оны 03-р сарын 10-ны байдлаар “Мэргэжлийн харилцаа”, Зөрчлийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулж, сургалтанд ажилтан, албан хаагчдын 75% хамрагдав. ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ыг мөрдөн ажиллаж байна.</p> <p>ХХҮГ-ын даргын 2018 оны А/01 дүгээр тушаалаар ажилтан, албан хаагчдын “Цаг ашиглалтын журам”-ыг батлан, мөрдөн ажиллаж байна. Цаг ашиглалтын журмын дагуу ажлын цагаар гадуур ажилласан тухай тэмдэглэлийг бүртгэл хяналтын дэвтэрт бүртгэж байна. Цаг ашиглалтын журам мөрдөж эхэлснээс хойш нийт ажиллагсадаас 13 албан хаагч ажлын цаг хоцорсон ба өмнөх сартай харьцуулахад 23% буурч, ажилчдын цаг ашиглалтад эерэг нөлөө үзүүлсэн байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Байгууллагын ажилтан, албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 12 заалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2018 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан албан хаагчдыг чадавхижуулах сургалт, зөвлөгөөн”-ийг 4 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Баруун-Урт суманд зохион байгууллаа. Уг сургалтаар нийт 48 ажилтан албан хаагчид хамрагдсан.</p> <p>ХХҮГ-ын даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг төрийн захиргааны 32 мэргэжилтэн, хөдөлмөрийн гэрээг төрийн үйлчилгээний 16 ажилтан, нийт 48 ажилтан, албан хаагчид 2018 оны 04 дүгээр сард байгууллаа. Гэрээний хавсралтаар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” 4 заалт бүхий батламж бичигт нийт 48 ажилтан, албан хаагчид гарын үсэг зурж баталгаажуулаад байна.</p>	
16	СЭЛЭНГЭ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>“Ажлын байранд мөрдөх хэм хэмжээ” –ний журмын дагуу Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажил төрлийн харилцаанд хэрхэн орох, хувцаслах соёл, цаг ашиглалт, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах шаардлага тавьж, ХХҮГ-ын нийт ажилтан, албан хаагчидтай 2018 онд хариуцлагын гэрээ шинэчлэн байгуулаад байна.</p> <p>Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг эрүүл мэнд, боловсрол, шагнал урамшуулал, цэргийн албан хаасан байдал, амьдралын нөхцөл, хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй эсэх болон амьжиргааны түвшин зэрэг 22 чиглэлээр авч цахим сан</p>	

		<p>үүсгэв.</p> <p>Байгууллагын өмч хамгаалах комисс хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар үр дүнг тооцон, холбогдох албан тушаалтанд танилцуулж ажилласан. Мөн байгууллагын автомашины ашиглалтын журмыг баталж, ажил үүрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороо нь ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байран дээр чадавхижуулах сургалтанд хамруулах, хувь хүний хөгжил, харилцаа, хандлагын талаар ажиллаж байна.</p> <p>Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянах шийдвэрлэх зорилгоор байгууллагын ёс зүйн хороог ХХҮГ-ын даргын тушаалаар байгуулан, 11 зорилт бүхий төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газартай хамтран “Төрийн болон Албаны нууцын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.</p> <p>Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 117 дугаар тогтоолоор батлагдсан “Архидалттай тэмцэх” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сэлэнгэд амьдрах сайхан” ТББ-ын тэргүүн, илтгэгч Д.Ганбатын “Архидалтын шалтгаан, зан үйлийн эмгэг буюу F-10”-ын талаарх лекц, аймгийн Цагдаагийн газрын архидан согтуурахтай тэмцэх ажил хариуцсан ахлах байцаагч Цагдаагийн хурандаа Т.Цэрэнбат, Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч Цагдаагийн хурандаа Ц.Батсүх нартай хамтран сургалт зохион байгуулснаар архидалтын шалтгаан, нийгэмд учруулж буй хор уршгийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлж ажиллалаа.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагуудын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн дагуу байгууллагын зорилт, чиг үүргийн өөрчлөлттэй уялдуулан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тус газрын ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, хандлагыг өөрчилснөөр ажлын цагтаа багтан ажил үйлчилгээгээ гүйцэтгэх, гэрэл цахилгаан, цэвэр, бохир усны ашиглалтыг сайжруулан зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн байгууллагын ажилчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, зорилтот ажил үйлчилгээг оновчтой, нэгдмэл байдлаар зохион байгуулснаар томилолтоор ажиллах хугацаа болон тоо багасан, томилолтын зардал буурч хэмнэгдлээ.</p> <p>Нийт ажилтан, албан хаагч, мэргэжилтэн нартай хариуцлагын гэрээ байгуулж өөрийн хариуцсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд ариг гамтай хандах, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах талаар гэрээнд тусган ажиллалаа.</p>	
17	ТӨВ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, зөрчлийн талаар өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй “Ёс зүйн хороо”-г байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. “Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх журам” боловсруулж, ажлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх аргачлалыг тодорхойлон, мөрдөж</p>	

		<p>байна.</p> <p>Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг авах талаар Байгууллагын цахим хуудсанд холбоос оруулж, нээлттэй утас ажиллуулж байна.</p> <p>Байгууллагын 2017-2020 оны “Сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, 2018 оны сургалтын хэрэгцээний судалгааг авч, төлөвлөгөөний дагуу сумдын мэргэжилтнүүдийн сургалтыг 03 сарын 22-23-нд зохион байгууллаа. Сургалтаар “Хувь хүний хандлага, манлайлах чадварыг хөгжүүлэх” хичээлийг Ганавелл сургалтын төвтэй хамтран явуулсан.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан, “Авлигагүй албан хаагчийн баталгаа”-г шинэчилэн албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, чөлөө авах асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар нарийн зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байна. Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд газрын даргад өргөдөл гаргаж, чөлөөний хуудсаар зөвшөөрөл авч байна. Ажлын цагийн бүтээмж, гүйцэтгэсэн ажлын чанарт хэлтсийн дарга нар өдөр тутмын хяналт тавьж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг үр дүнгээр тооцож ажилладаг.</p> <p>Албан хаагчдын 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулах, ажлын төлөвлөгөөг батлах үйл ажиллагааг 2 сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Сумын мэргэжилтнүүд сумын Засаг дарга, ХХҮГ-ын даргатай “Гурвалсан гэрээ” байгуулж, орон нутагт ажиллах мэргэжилтний ажлын гүйцэтгэл, өдөр тутмын цаг ашиглалт, иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хяналт тавьж ажиллахаар тусгалаа. Мөн байгууллагын нэгжүүд болон үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан, сар бүр дүгнэж байна. Ажлын байранд мөрдөх хэм хэмжээг нийт албан хаагчид мөрдөн, шинээр томилогдсон албан хаагчдад тухай бүр танилцуулж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Үйлчлүүлэгч иргэдээс албан хаагчдын зан харилцаа, ёс зүйн зөрчлийн талаар санал асуулга авч, үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж хэвшсэн. Дотоод хяналтын төлөвлөгөө батлан, төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, илтгэх хуудас, тайлан мэдээг мэдээллийн самбарт ил тод байршуулж, зөрчил гаргасан албан хаагчид үүрэг даалгавар, зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулсан.</p> <p>Байгууллагын соёл, албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор 5с зарчмыг хэрэгжүүлэх 35 хоногийн ажлын төлөвлөгөө, удирдамж боловсруулж байна. 4 сарын 23-ны өдрөөс эхлэн байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулж, төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэнэ. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Чанарын менежментийн тогтолцооны талаарх сургалтанд хамрагдаж зохих мэдээлэл авлаа.</p>	
18	УВС	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Газрын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах талаар сургалт зохион байгуулж, үр дүнгийн гэрээнд тусган, зөрчсөн төрийн үйлчилгээний 3 албан хаагчдад сануулах сахилгын шийтгэл авч ажиллалаа. Хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан МУИС-ийн багш нарын зохион байгуулсан сургалтанд байгууллагын удирдах ажилтан 5 хүнийг хамрууллаа. “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ыг танилцуулж, сургалт зохион байгуулсан ба Төрийн албаны ёс зүйн дүрмийг ажилтан, албан хаагч бүрийн “Ширээний мэдээлэл”-д байршуулан, өдөр тутмын</p>	

		<p>үйл ажиллагаанд мөрдлөг болгож байна.</p> <p>Газрын 2017 оны ажлын тайлан, шинээр батлагдсан хууль тогтоомжийг 19 сумын 2571 иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлж, 900 гаруй иргэнээс чанарын судалгаа авч, иргэдийн саналыг 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.</p> <p>ХХҮГ-ын 1 дүгээр давхарт ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах бүртгэл болон үйлчлүүлэгчдийг угтах үйлчилгээ бий болгож, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлээ.</p> <p>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</p> <p>Сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2018 оны 04 дүгээр сарын 06-07-нд зохион байгуулж ажиллалаа.</p> <p>“Санал хүсэлтийн хайрцаг”-ийг 1, 2 дугаар давхарт байршуулан, сар бүрийн 25-ны дотор нээж, иргэдээс ирсэн санал хүсэлтийг албажуулан бүртгэж, байгууллагын удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтнүүдийг үүрэгжүүлж, ажил үйлчилгээндээ зөрчил дутагдал давтан гаргахгүй байлгахад анхаарч байна.</p> <p>Газрын 2018 оны 01 дүгээр улирлын ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох зорилгоор Улаангом сумын 137 үйлчлүүлэгч иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны үр дүнг ажлын төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.</p> <p>ХХҮЕГ-аас 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр тус тус зохион байгуулсан цахим хурлын үр дүнд 19 сумын Засаг дарга, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 220 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлж ажиллалаа.</p> <p>Тэмүүлэл Увс ТББ-тай хамтран “Төсөл бичих аргазүй” сургалтыг зохион байгуулж, 36 иргэнийг хамруулсан. Мөн Аймгийн ЗДТГ-ын НБХ-тай хамтран өрх толгойлсон 29 эхчүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж хүндэтгэл үзүүлсэн.</p>	
19	ХОВД	<p>2018 оны 1 дүгээр улирал</p> <p>МУ-ын Ерөнхий сайд Ховд аймгийн иргэд хөдөлмөрчид, төрийн албан хаагчидтай уулзаж, төрийн албан хаагчид иргэддээ төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд чанартай, түргэн шуурхай хүргэж хариуцлагатай ажиллах, хариуцлага тооцдог байх талаар үүрэг, даалгавар өгсөн. Уулзалтанд төрийн албан хаагчдыг бүрэн хамрууллаа.</p> <p>Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан хаагчдын ёс зүйн дүрмийг танилцуулж, мөрдөн ажиллаж байна. Мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн өөрчлөлт оруулж, ажлын байрыг нь сэлгэн ажиллуулж байна.</p> <p>Тус газар нь тусгай цаг бүртгэгчтэй бөгөөд ажилчдын өглөө ирсэн, өдөр цайнд гарсан, орой тарах цагийг нарийн бүртгэдэг. Мөн ажлын цаг ашиглалтын тусгай журам боловсруулан мөрдөж байна.</p> <p>Сул чөлөөтэй орон тоонд хүн авч ажиллуулахгүй ажлын байрны нягтралыг сайжруулж, мөн орлогоор цалинждаг харьяа байгууллагын ажилчдын цалинг цалингийн сангаас гаргахгүй ажиллаж байна.</p> <p>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</p>	

		<p>2018 оныг “Сахилга хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн нийт 5 ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцон сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авч ажиллалаа. Мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн өөрчлөлт оруулж, ажлын байрыг нь сэлгэн ажиллуулж байна. Ингэснээр мэргэжилтнүүд нэг ажлын байрандаа удаан байж хүнд суртал гаргах, иргэдээс шан харамж авах зэрэг эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүнд суртал гаргахгүй байх давуу талтай боллоо.</p>	
20	ХӨВСГӨЛ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг өөрчилж, нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг төрөлжүүлэн, иргэдийн үйлчилгээ авах нөхцөл, албан хаагчдын шуурхай байдлыг нэмэгдүүллээ.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйг ханган ажиллах зорилгоор 2018 оны 3 сард ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, үр дүнгийн гэрээний тусгай арга хэмжээнд 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах тухай үүрэг болгон ажиллаж байна.</p> <p>Мөн ажлын байрны бүтээмж, эмх цэгц, дэг журмыг сайжруулах зорилгоор 5с соёлыг нэвтрүүлэх ажлын хэсэг гарган ажиллаж байна. 5с соёлыг хэрэгжүүлэх хүрээнд ажилтан, албан хаагчдад мэдээлэл сургалт хийн гарын авлага тарааж, 1с соёлыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Аймгийн ХХҮГ, ЭМНДХ, ХГБЗХГ, МСҮТ гэсэн 4 байгууллага нь “Халамж хүртэгчээс баялаг бүтээгчдийг дэмжинэ” уриан дор нийгмийн салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг аймгийн 23 сум, 1 тосгоны иргэдэд хүргэх ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс зохион байгуулж, хуваарийн дагуу Төмөрбулаг, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумдад ажиллалаа.</p> <p>ХХҮГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг нийт 950 гаруй иргэдэд Төрийн бодлого, хууль журам, ХНХЯ, дээд байгууллагаас баримталж байгаа шийдвэрийг танилцуулж ажилласан. 2018 онд ХЭДС-аас хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн нээлтийг хийж сум бүрт хийж, сумын АДЗ-ийн гишүүдэд сургалт зохион байгуулж байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын өдрийг тохиолдуулан албан хаагчдын дунд эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж хэвшсэн. 2018 онд тус эрдэм шинжилгээний бага хурал, илтгэлийн уралдаанд 5 мэргэжилтнийг хамруулж, байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан манлайллын баг хариуцан ажиллаж байна.</p> <p>Мөрөн сумын “НЭГ ЦЭГ”-ийн үйлчилгээг засварлаж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, иргэдийн тав тухтай үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлсэн.</p> <p>5с зарчим хэрэгжүүлж, өрөө тус бүрийг баг болгон өрсөлдүүлэх, Манлайллын багийг 2 болгож зөв өрсөлдөн хөгжих боломжийг бүрдүүлсэн бол төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас ажлын байранд эмх цэгцийг бий болгох, соёлч боловсон хувцаслах, харилцааны соёлыг бусдад үлгэрлэх, ажлын байрны дэг журмыг тогтоох санамжийг хэрэгжүүлээд байна.</p>	
21	ХЭНТИЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сэдвээр мэдээлэл, сургалтыг ХХҮГ, сумдын</p>	

		<p>мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Иргэдэд үйлчлэх үйлчилгээний стандарт”-ыг чанд мөрдөж, газрын даргаас ажилтан, албан хаагчидтай байгуулсан сахилга хариуцлагыг сайжруулах 8 заалт бүхий “БАТАЛГАА”-г өдөр тутам мөрдөж байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эрхэмлэх 9 зүйлийг чанд мөрдөж, иргэдтэй эелдэг боловсон харилцаж, соёлтой, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажил үүрэгтээ мөрдлөг болгож байна. Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийг ажилтан, албан хаагч бүр судалж, ажил үүргийн хүрээнд олж мэдсэн аливаа нууцад хамаарагдах мэдээллийг бусдад задруулж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар ажлын байрны тодорхойлолтод тусган өгсөн. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг 3 дугаар сард газрын нийт мэргэжилтнүүдэд зохион явуулж, 45 мэргэжилтэн хамрагдаад байна.</p> <p>ХХҮГ-ын ажилтнуудын “Ажлын цаг ашиглалтад хяналт тавих журам”-ыг ажилтан, албан хаагч бүр баримтлан, ажлын хариуцлага алдсан 2 мэргэжилтнийг ёс зүйн хороогоор хэлэлцэн сахилгын шийтгэл тооцоод байна. Чөлөө олгох болон гадуур ажиллахад зөвшөөрлийн хуудас бичдэг болсноор ажилчдын цаг ашиглалт, ажлын байрны дэг журам сайжирсан.</p> <p>Харьяа дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн тушаал, албан даалгавар, төсөв төлөвлөгөө, судалгааг бодит баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөвөөр гаргаж, цаг хугацаанд нь шуурхай хүргүүлэн ажиллаж байна. Мөн байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилготой “Тайлан, мэдээ ирүүлэх журам”-ыг боловсруулан гаргаж байна.</p> <p>“Сумдын мэргэжилтнүүдийг чадавхижуулах арга зүйн сургалт”-ыг зохион байгуулж шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төсөл, хөтөлбөр арга хэмжээний талаар холбогдох мэргэжилтнүүд сургалт мэдээлэл хийснээс гадна газрын бусад мэргэжилтэн бүр өөрсдийн эрхэлсэн ажлын чиг үүргийн дагуу сургалт, мэдээлэл хийж, арга зүйн зөвлөгөө өглөө.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эрхэмлэх 9 зүйлийг чанд мөрдөн ажиллаж, “САХИЛГА-ХАРИУЦЛАГА, ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭЭ” уриа дэвшүүлэн иргэдтэй соёлтой харьцаж, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажил үүрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөний дагуу Баян-Адрага, Баянхутаг, Галшар сумдад хяналт шалгалтыг хийж зөвлөмж чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгөөд байна.</p>	
22	БАГАНУУР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хэлтсийн ажилтан, албан хаагчдын нийтийг хамарсан ажилд оролцсон байдал, цаг ашиглалт, эмнэлгийн хуудас, эмчийн магадлагааг үндэслэн чөлөөг олгож байна.</p> <p>Хэлтсийн даргын баталсан “Цаг ашиглалтын журам”-ын дагуу 1 өдрийн чөлөөг чөлөөний хуудсаар, чөлөө хүссэн өргөдлийг харгалзан цалингүй болон цалинтай чөлөөг олгож байна.</p> <p>Тэтгэмж, тусламж хариуцсан мэргэжилтэн, халамжийн сангийн мэргэжилтний сул орон тоонд Төрийн албаны шалгалт өгч тэнцсэн Б.Мөнхзаяа, Л.Даваажаргал нарын материалыг Нийслэлийн төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллалаа.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p>	

23	БАГАХАНГАЙ	<p>(тайлан ирээгүй)</p> <p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Албан хаагчдын ажил, үүргийн хуваарийг оновчтой болгох, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанар, үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор Ажлын байрны тодорхойлолтыг хэлтсийн даргын дэргэдэх зөвлөл шинэчлэн боловсруулж, албан хаагчдад танилцуулан ажиллаж байна. “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ын дагуу хувцаслалт, үс засалт, харилцааны соёл, биеэ авч явах болон баримтлах ёс зүй, ажлын байранд хориглох зүйл зэргийг мөрдөн ажилладаг.</p> <p>Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, цалинг төсөвтөө багтаан шатлалыг бууруулалгүй олгож, хоол унааны хөнгөлөлтийг сар бүр олгож байна. 1 албан хаагч өөрийн мэргэжлийн чиглэлээр магистр, 2 албан хаагч Удирдлагын академийн төрийн удирдлагын чиглэлээр суралцаж 2018 онд төгссөн.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Хэлтсийн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг 2018.04.03-ны өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, ёс зүйн хорооны бүрэлдэхүүн 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, ёс зүйн хорооны дүрэм, журмыг шинэчлэн албан хаагчдад танилцуулсан.</p> <p>2018 оныг тус хэлтсээс “Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” уриатайгаар албан хаагчдыг өөрийн хариуцсан ажил мэргэжлээ чанарын өндөр түвшинд, иргэдэд хүртээмжтэй хүргэхэд анхаарч ажиллахаар зорилт тавиад байна.</p> <p>Ажлын цаг бүртгэлийг ХШҮ хариуцсан мэргэжилтэн бүртгэн сар бүр ажил тасалсан, хоцорсон албан хаагчдыг ёс зүйн хороогоор хэлэлцүүлэн ажилласнаар албан хаагчдын цаг ашиглалт сайжирсан.</p> <p>Ажилтан, албан хаагчид ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/31 дүгээр тушаалын “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ын дагуу хувцаслалт, үс засалт, харилцааны соёл, биеэ авч явах болон баримтлах ёс зүй, ажлын байранд хориглох зүйл зэргийг мөрдөн ажиллаж байа.</p>	
24	БАЯНГОЛ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хэлтсийн албан хаагчдад төрийн албаны ёс суртахуун, ёс зүйн сургалт зохион байгуулж, шинээр томилогдсон албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуулж ажиллалаа. Байгууллагын албан хаагчдын ажлын байрны эрсдлийн үнэлгээ гаргаж, танилцуулга, гарын авлагыг вэб сайт, мэдээллийн самбарт байршуулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.</p> <p>“Ажлын байран дахь стресс, түүнийг хэрхэн даван туулах” сэдвээр 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ажилтан, албан хаагчдын дунд нээлттэй ярилцлага өрнүүлсэн. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт бүрэн хамруулснаар 1 албан хаагчийн элэгний хавдрыг эрт илрүүлэн цаг алдалгүй хагалгаанд орж, эмчилгээ үр дүнгээ өгсөн байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, “Халамжаас- Хөдөлмөрт” өдөрлөг, “ХАБЭА хувь хүний зан төлөв” сэдэвт өдөрлөг, ажилчин албан хаагчдын чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p>	

		<p>АТГ-ын ОНХТ-өөс зохион байгуулж буй сургалтанд хуваарийн дагуу албан хаагчдыг бүрэн хамруулж тайлан мэдээг хугацаанд нь явууллаа.</p> <p>Нийгмийн халамжийн албанаас 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр АДЗ-ийн хурлаар шийдвэрлэсэн Нийгмийн халамжийн үйлчилгээний “Ололт амжилт” онол практикийн анхдугаар бага хурал зохион байгуулсан нь албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэхэд тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх гарц, үр дүнг сайжруулах, шинэ санал дэвшүүлсэн цаг үеэ олсон ажил боллоо.</p> <p>Нийгмийн даатгалын хэлтсийн хяналтын байцаагчийг урьж Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар сургалт зохион байгуулснаар мэргэжилтнүүд нэгдсэн ойлголттой болсон.</p>	
25	БАЯНЗҮРХ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Төрийн албан хаагчийн шударга ёс, хуулийг дээдлэх, тэгш байдлыг хангах, хариуцлага хүлээх, олон нийтэд үйлчлэх ёс зүйн хэм хэмжээг баримталж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг хэлтсийн албан хаагчдад 2018 оны 03 сарын 22-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэж, зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцон ажиллаж байна. Ажлын байрны тодорхойлолтын шинэчлэхээр албан хаагч тус бүрээс саналыг авч байна.</p> <p>Албан хаагчдын цалин хөлсийг олгож, шилэн дансны мэдээллийг 2018 оны 3 дугаар сарын 09-ний өдөр оруулсан. Байгууллагын эд хөрөнгийг зөв зохистой ашиглах, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллахад хяналт тавьж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан хэлтсийн үр дүнгийн гэрээ байгуулах үйл ажиллагаанд Хүний нөөцийн менежментийн академийн сургагч багш н.Лхагва-Очир “Харилцаа ба хандлага” сэдэвт лекц уншиж, хэлтсийн 75 албан хаагчид хамрагдав.</p> <p>2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр тус хэлтсийн хороо хариуцсан 32 мэргэжилтэнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Э.Ганбат зохион байгууллаа.</p> <p>Авлигатай тэмцэх газрын Олон нийттэй харилцах төвд батлагдсан хуваарийн дагуу 4 сарын 13-ны өдөр ХЭА-ны дарга Д.Нямаа сургалтанд хамрагдаж, хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгууллаа.</p> <p>Ажилтнуудын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, ажил дүгнэх үзүүлэлтэд тусгалаа.</p>	
26	НАЛАЙХ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хамт олны хурлаар нэр дэвшүүлэн 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Ёс зүйн хороог шинэчлэн баталсан. Ёс зүйн хорооны ажиллах журам, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Тус хороо 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр нийт албан хаагчдад ёс зүйн мэдэгдлийг танилцуулан, гарын үсэг зуруулж баталгаажууллаа. “ХАСХОМ-ийг гаргах эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад явуулж, гарын авлага болон шаардлагатай</p>	

		<p>мэдээллийг өгч ажилласан.</p> <p>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, хариуцлага, ажлын үр дүнг сайжруулах тухай” А/17 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 02 дугаар захирамжийн дагуу хэлтсийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор “Цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих журам”-ыг батлан мөрдүүлж байна. Журамд хугацаатай үүрэг даалгавар, түүний бүртгэл, хэрэгжилтэд хяналт тавих, төрийн захиргааны албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтэд тооцон үнэлэх зэрэг асуудлыг тусгасан байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Нийт албан хаагчид Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны хувьд хууль дээдлэх зарчимд захирагдан албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш шударга, хариуцлагатай гүйцэтгэж албаны бүрэн эрхээ хувийн болон өөрт хамаарал бүхий иргэдийн хувийн зорилгод ашиглахгүй, албан үүрэгт нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байж, ёс зүйг сахин, шударга ажиллахаа нийт иргэд, албан хаагчдын өмнө мэдэгдэж, 6 заалт бүхий “Ёс зүйн мэдэгдэл”-ийг мөрдөн ажиллаж байна.</p> <p>Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд гадуур ажлаар явсан тухай тэмдэглэл хөтлөх дэвтрийг тогтмол хөтлүүлж, чөлөөний хуудсаар чөлөө олгож хэвшүүлэн, нэгтгэлийг гарган хяналт тавьж, олон нийтийн оролцооны бүртгэлийг оноожуулах систем ашиглан ажил дүгнэх үзүүлэлтийн нэг болгох зэргээр “Цаг ашиглалтад хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
27	СҮХБААТАР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нийт 27 мэргэжилтэнд зориулсан Төрийн албаны зөвлөлийн “Гүйцэтгэлийн удирдлага” сэдвээр сургалт зохион байгуулж, 2018 оны байгууллагын төлөвлөгөөг танилцуулан, үр дүнгийн гэрээнд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтын талаар чиглэл өгч ажилласан.</p> <p>2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар иргэдээс Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвд ирүүлсэн 3 өргөдөл, гомдлыг бүрэн шийдвэрлэж, ажилласан. Албан хаагчтай холбоотой өргөдөл 3 ирсэн бөгөөд тухайн албан тушаалтанд сануулах арга хэмжээ авсан.</p> <p>ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Ажлын байранд дагаж мөрдөх хэм хэмжээний журам”-ыг мөрдөн ажиллаж байна. 2018 оны 03 дугаар сарын 18-ны өдөр албан хаагчийн цаг ашиглалт, ажлын байрны дэг журмыг сахин ажиллаж байгаа байдалд шалгалт хийж, алдаа дутагдалтай ажиллаж байгаа болон ажлын байранд дагаж мөрдөх журамд заасан дүрэмт хувцас өмсөөгүй байгаа мэргэжилтнүүдэд сануулга өглөө.</p> <p>2018 оны “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөө”-г 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.</p> <p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2018.02.23-ны 551 дугаар албан бичгээр тус хэлтсийн үйл ажиллагаа зөрчилгүй дүгнэлт, 2018.02.23-ны 550 дугаар албан бичгээр Халамжийн сан зөрчилгүй дүгнэлт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2018.02.23-ны өдрийн 01/32 дугаар албан шаардлагаар 1</p>	

		<p>зөрчил арилгах дүгнэлт тус тус ирсэн.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> Хэлтсийн хэмжээнд хоцорсон албан хаагчдыг өдөр бүр байгууллагын facebook группт, мэдээллийн самбарт нэр, хоцорсон минутаар танилцуулж байна. Хоцролт, болон ажлын байрыг эзгүй орхих зэрэг нь эрс багасч цаг ашиглалт сайжирсан. Алдаа дутагдалтай ажиллаж байгаа, ажлын байранд дагаж мөрдөх журамд заасан дүрэмт хувцсаа өмсөөгүй байгаа мэргэжилтнүүдэд тухай бүр сануулга өгч ажиллаж байна.</p> <p>2018 оны ажлын төлөвлөгөөний дагуу тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа 3 албан хаагчийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрөөр шагнуулахаар тодорхойлсон.</p>	
28	СОНГИНОХАЙРХАН	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u> Тайлангийн хугацаанд ажлын байрны дэг журам зөрчсөн 6 албан хаагчид сахилгын арга хэмжээ ногдуулсан. 2018 оны 03 дугаар сарын байдлаар иргэдээс Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвд 5 гомдол, 2 хүсэлт ирүүлсэн байна. Дээрх 5 иргэний гомдлыг ажлын 1 өдөрт багтаан барагдуулж, иргэнд утсаар мэдэгдсэн. 2 хүсэлтийг ажлын 2 хоногт шийдвэрлэж, иргэнд хариу өгсөн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр гарган, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тайлагнаж байна.</p> <p>Сар бүр албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг тооцож, шаардлагатай тохиолдолд байгууллагын Ёс зүйн хороогоор уг асуудлыг хэлэлцүүлж байна. Хэлтсийн нийт төрийн жинхэнэ албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан. Мөн албан даалгаврын хүрээнд нийт албан хаагчидтай Хариуцлагын гэрээ байгуулахаар бэлтгэл ажлыг хийж байна.</p> <p>Байгууллагын өмч хөрөнгийн 2017 оны тооллогын дүнг Өмч хамгаалах комисс хэлэлцэж, өмч хөрөнгийг бүртгэлийг сайжруулах, сери, дугаарыг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна. Нийт албан хаагчидтай байгуулах үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд эд хөрөнгийн хариуцлагын талаар тусгав.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u> Албан даалгаварын хүрээнд нийт албан хаагчидтай Сахилга дэг журам, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд батлагдсан нийслэлийн Засаг даргын 2017 оны 02 дугаар захирамж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны А/287 дугаар тушаал зэрэг эрх зүйн баримт бичиг болон 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан.</p>	
29	ЧИНГЭЛТЭЙ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u> 2018 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх 15 зорилт, 25 арга хэмжээ бүхий Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллаж байна.</p> <p>Ажлын байрны тодорхойлолтын төсөлд болон ажилтнуудын үр дүнгийн гэрээнд шударга ёсны шалгуур, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тодорхой шалгуур үзүүлэлтийг тусгасан.</p> <p>“Смарт сити” өргөдөл, гомдлын програмын ашиглалтын талаар албан хаагчдад сургалт явуулах хүсэлтийг Нийслэлийн ЗДТГ-т албан бичгээр гаргаж, 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс өргөдөл, гомдлын http://www.smartcity.mn програмын хэрэглээ, ашиглалтын</p>	

		<p>талаар хичээл заасан. Тус сургалтанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн нийт албан хаагч хамрагдсан. Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг үндэслэн ажлын чиг үүрэг, баримт бичгийн эргэлт, боловсруулалт, хяналтыг сайжруулах зорилгоор Албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэн баталж, албан хаагчдад танилцуулан мөрдөж байна.</p> <p>Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор хэлтсийн Дундын хуримтлалын сан байгуулах, хэрэгжүүлэх журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн баталлаа. Хүний нөөцийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам боловсруулахдаа албан хаагчдын хурлаар хэлэлцэн саналыг тусгав. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас авсан.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны болон Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны зарцуулалтад Нийслэлийн аудитын газраас шалгарсан “Мэдээлэл аудит” ХХК шалгалт хийсэн. Тус аудитын нэгдсэн дүгнэлтээр үйл ажиллагааны болон Нийгмийн халамжийн сангийн үйлчилгээ, зарцуулалт “зөрчилгүй”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйлчилгээ, зарцуулалт “хязгаарлалттай” дүгнэлт авсан.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>2018 оны 04 дүгээр сарын 9,10,16-ны өдрүүдэд АТГ-аас зохион байгуулагдсан “Ашиг сонирхлын зөрчил”, “Төрийн албаны ёс зүй”, “Авлига ба хүний эрх”, “Ялын төрөл”, “Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид хуваарийн дагуу бүрэн хамрагдлаа. Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу Зөрчлийн тухай хуулийн мэдлэг олгох сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулав.</p> <p>Нийслэлийн Нийгмийн халамжийн газраас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн сургалтанд бичиг хэргийн ажилтан, архивын эрхлэгч нар 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хамрагдлаа. Нийслэлийн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн сүлжээний ашиглалт, хяналтыг сайжруулах сургалтыг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан хороодын мэргэжилтнүүдэд 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, 22 мэргэжилтэн хамрагдав.</p>	
30	ХАН-УУЛ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Дүүргийн 16 хороог “Жишиг хороо” болгох зорилтыг хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээнд тусгаж байна.</p> <p>Хэлтсийн даргын 2018.02.06-ны өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулсан орон тооны бус зөвлөл, хороо, комиссууд 2018 оны турш хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулсан.</p> <p>Тухайн цаг үеийн холбоотой мэдээ, мэдээллийг солилцох, танилцуулах, нэгдсэн нэг ойлголтод хүрэх зорилго бүхий долоо хоног бүрийн Мягмар гарагийн “ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ийг 2 дугаар сарын 27, 3-р сарын 6, 13, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Мягмар гарагийн хэлэлцүүлэг бүрт “Гадуур ажлын дэвтэр”-ээ хөтлөж байхыг сануулж хэвшсэн. Бүртгэл хөтөлснөөр “Ажлын байранд мөрдөх хэм хэмжээний журам”-ыг хангах комисс сар бүрийн ажлаа дүгнэж, үр дүнг мэргэжилтэн бүрт танилцуулан зөвлөгөө өгч байна.</p> <p>“ПҮРЭВ ГАРАГ-БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ” төлөвлөгөөт сургалтаар:</p> <ul style="list-style-type: none"> - ХХҮЕГ-ын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтнийг урьж “Зорилтот 	

өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн Өрхийн хөгжлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, хянах арга зүйн талаар сургалт зохион байгуулсан. Сургалтанд хороо хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсанаар өөрсдийн ажлын чиг үүргийг зохион байгуулах мэдлэг сайжирсан.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар шинээр томилогдсон мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулав.
- Шинээр томилогдсон болон хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа эргэн томилогдсон албан хаагчдад Шинэ ажилтны сургалт зохион байгуулж, байгуулагын дотоод үйл ажиллагаа, хэрэгжиж буй хууль журмын талаар мэдээлэл хүргэлээ. "ШИНЭ АЖИЛТНЫГ ЧИГЛҮҮЛЭХ ГОРИМ"-ын хуудсыг хөтлүүлэн, анхны сэтгэгдэл болон саналыг хүлээн авч хувийн хэрэгт хавсаргалаа. Шинэ томилогдсон албан хаагчдад Ажлын байрны тодорхойлолтыг танилцуулсан. Ингэснээр ажлын ачааллаа зөв хуваарилах, сар бүрийн мэдээ тайланг хоцроолгүй, хариуцлагатай өгөх үүрэг хүлээлгэлээ.
- Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд албан тушаалд шинээр болон сэлгэн томилогдсон 5 албан хаагчийг 8 цагийн сургалтанд хамруулж, сургалтын тайлан, үр дүнг гаргууллаа. Иргэдэд үйлчлэх "Шударга, шуурхай-ил тод" мэдээллийн самбарыг 3 дугаар сард Халамжийн сангийн зарцуулалт гүйцэтгэлийн мэдээ, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах хууль журмын мэдээллээр шинэчилсэн.

Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 03 сарын 13-16-ны өдрүүдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн иргэдэд сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/205 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан хүнсний эрхийн бичиг олгох журам, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд хэрхэн хамрагдах, харилцагч банк, хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагааг иргэдэд таниулах, МУ-ын Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн зорилго, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гүйцэтгэх чиг үүрэг, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болох төсөл хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломж нөхцөлийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажиллав.

"АЖИЛ, АМЬДРАЛЫГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР-2018"-ийн дагуу 3 дугаар сард цалинтай чөлөө авсан ажилтан, албан хаагчид: төрсөн өдрийн чөлөө авсан -3, дотоод журамд заасан чөлөө-1, эрүүл мэндийн чөлөө авсан-1, бусад шалтгаанаар чөлөө авсан-4 албан хаагч байна.

Хэлтсийн даргын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/07 дугаар тушаалаар "Хэмнэлтийн журам" баталсан. Уг тушаалын хавсралтад зорилго бүхий Эрчим хүчний хэмнэлт, Усны хэмнэлт, Бичиг хэргийн хэмнэлт, Холбооны хэмнэлтийг тус тус багтаан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2018 оны 04 дүгээр сарын байдлаар:

1-р улирлын байдлаар 1,5,7,8,9,11 хорооны мэргэжилтнүүд жишиг хороо болох чиглэлийн дагуу шинэлэг ажлуудыг зохион байгуулж, хорооны үйлчилгээний чанарыг сайжруулсан. Долоо хоног бүрийн Мягмар гарагийн "ХЭЛЭЛЦҮҮЛЭГ"-ийг 4-р сарын 3,10,17-ны өдрүүдэд зохион байгуулсан.

"Пүрэв гараг-байгууллагын хөгжил" төлөвлөгөөт сургалтын цагаар Хан-Уул дүүргийн хууль эрх

		<p>зүй, архивын тасагтай хамтран “Зөрчлийн тухай хууль”, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Давс түүний хэрэглээ”, “Зохистой хооллолт” сэдвээр сургалтыг зохион байгуулж, хэлтсийн мэргэжилтнүүд тус тус өөрсдийн хариуцсан асуудлаар мэдээлэл өгч ажилласан.</p> <p>2018 оны 03-р сарын 28-наас 04-р сарын 06-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 16 хорооны Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан өрхийн 519 иргэнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн зорилго, Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээ хийх арга зүй аргачлал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох ажлын байр нэмэгдүүлэх зээл, ажлын байрны захиалга, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрүүдийн тухай танилцуулж, ажил хайгч иргэнийг бүртгэж, ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>“Ажил, амьдралыг тэнцвэржүүлэх хөтөлбөр-2018”-ийн дагуу 4-р сард цалинтай чөлөө авсан ажилтан, албан хаагчид: төрсөн өдрийн чөлөө авсан -1, дотоод журамд заасан чөлөө-1, эрүүл мэндийн чөлөө авсан-3 тус тус байна.</p>	
31	НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын талаар албан хаагчдаас авах Мэдлэг шалгах сорилын тестийг боловсрууллаа.</p> <p>Тус газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв хариуцсан ахлах мэргэжилтэнд нэр дэвшсэн С.Нарантуяа болон Сургалт судалгааны хэлтсийн даргад нэр дэвшсэн С.Нямдорж нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хууль тогтоомжийн дагуу Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилсон болно.</p> <p>Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэлд тогтмол хяналт тавьж ажилласан ба 1, 2 дугаар сарын дүн мэдээг байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулж, газрын хурлаар хэлэлцсэн. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан оновчтой шийдэл, шинэ санал, санаачилга, төсөл, хөтөлбөрийг дэмжих, туршин нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2018 оны А/04 дүгээр тушаалаар нийт албан хаагчдын дунд болзолт уралдаан зохион байгуулах удирдамж, төсвийг баталсан.</p> <p>Болзолт уралдааныг 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлүүлсэн ба хугацаандаа ирүүлсэн 2 албан хаагчийн материалыг судалж байна. 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр шалгаруулалтыг зохион байгуулна. Албан хаагчдыг хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 03 дугаар сард 1 албан хаагчийн бэлтгэсэн мэдээллийн сонсголыг нийт албан хаагчдын дунд зохион байгууллаа.</p> <p>Сангийн сайдын 2017 оны 348 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал”-ыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хөтөлж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын талаарх мэдлэг шалгах сорилыг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын нийт албан хаагчдаас авч дүгнэв.</p>	

		<p>Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын нийт албан хаагчдад эрүүл амьдралын хэв маяг төлөвшүүлэх, эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс биологийн нас, ус, кальц, дотор, гадар өөхлөлтийн хэмжээ, илүүдэл жин, булчингийн хэмжээ зэрэг үзүүлэлтээр биеийн ерөнхий бүтцийг тодорхойлон, зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Зардал бууруулах болон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах чиглэлээр нийт албан хаагчдын дунд 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр сургалт зохион байгууллаа.</p>	
32	НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗАР	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Хамт олны 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар Ёс зүйн хорооны гишүүдийг сонгох санал асуулгыг авч, олонхийн санал авсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Байгууллагын ёс зүйн хороог шинэчлэн байгуулсан. 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд Smartcity.mn сайтаар нийт 70 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг цаг алдалгүй бүртгэн шилжүүлснээс 63-ийг шийдвэрлэн, 7 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатандаа явж байна. Өргөдөл гомдол шийдвэрлэх дундаж хугацаа 3 хоног 1 цаг байна.</p> <p>Байгууллагын http://ub.hudulmur-halamj.gov.mn/ цахим хуудсанд газрын даргын тушаал, зохион байгуулсан үйл ажиллагааны талаар 45 мэдээ, мэдээллийг тухай бүрт нь байршуулан иргэд олон нийтэд мэдээллээ.</p> <p>Байгууллагын цаг ашиглалтын журмын хэрэгжилтийг хангах үүднээс өдөр бүр албан хаагчдын цагийг бүртгэж, 7 хоног бүр нэгтгэн танилцуулж байна. Албан хаагчид гадуур ажлаар явах тохиолдолд гадуур ажлын дэвтэрт бүртгэж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Ёс зүйн хороо нь 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хуралдаж ёс зүйн хорооны 2018 оны төлөвлөгөөг баталж, журмыг шинэчлэн нийт албан хаагчдад танилцуулсан. Уг төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 18-наас 20-ны өдрийн хооронд нийслэлийн 152 хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан 168 мэргэжилтэнд “Харилцааны ёс зүй, стресс менежмент” сургалтыг Удирдлагын академи, Лэди төвийн багш нартай хамтран зохион байгуулсан. Байгууллагын ёс зүйн хорооны дарга 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр газрын 15 албан хаагчидтай байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн жинхэнэ албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэж ажиллах тухай “Ёс зүйн гэрээ”-г байгуулан ажиллалаа.</p> <p>Газрын даргаас нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга болон газрын дэд дарга, захиргаа, санхүү, хяналтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нартай “Ёс зүйн мэдэгдэл”-ийг 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгууллаа.</p>	
33	АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Ахмад настны үндэсний төвийн “Үйлчлүүлэгчдийн дагаж мөрдөх журам”-д заасны дагуу үйлчлүүлэгч нь өдөрт 2 цагийн хөнгөн хөдөлмөр эрхлэх журамтай холбогдуулж, байгууллагын өргөтгөлийн байрны үүдэнд ээлжийн жижүүрийн цагийн хуваарь гарган ажиллуулж байна. Мөн үйлчлүүлэгчдээс хариуцлагатай жижүүрийг сонгон амралтын өдрүүдэд давхар томилон ажиллуулж байна.</p> <p>Шаардлагатай ажил мэргэжлийн ажилтан, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах,</p>	

		<p>төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах талаар санал асуулга авч байна.</p> <p>2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Цэвэрлэх байгууламжийг барих 250 сая төгрөг шийдвэрлүүлж, бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Захиргаа, нийгмийн оролцооны албаны ажилтан, албан хаагч нар “Нээлттэй нэг өдөр”-ийг зохион байгуулж, хууль эрхзүй, дүрэм, журам, цалин хөлс, нийгмийн даатгал, бичиг хэргийн талаар нийт ажилчдад мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах үүднээс 4-6 айлын ажилчдын байр барих асуудлыг хэлэлцэж ажиллаж байна.</p>	
34	<p>БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ</p>	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Мэргэжилтнүүдийн хэлний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Сөүл Глобал төвөөс гадаад иргэдэд зориулж хэрэгжүүлдэг солонгос хэлний сургалтыг зохион байгуулж байна. Солонгос хэлний болон бусад курст 4-5 мэргэжилтэн хамрагдлаа.</p> <p>Мөн хөдөлмөрийн гэрээт ажилчдын хөдөлмөрийн харилцаанд тулгардаг асуудлууд болох үйлдвэрлэлийн осол, олгогдоогүй цалин хөлс, цалин бодох журамтай холбоотой хууль тогтоомжийн талаарх сургалт, зөвлөгөөг БНСУ-ын төрийн болон төрийн бус байгууллагуудаас шат дараалалтай авч хэрэгжүүлж байна. Иргэддээ төрийн үйлчилгээг ойртуулан “Амралтын өдрөөр ажиллаж иргэдээ сонсох” ажлыг эхлүүллээ. 3 сарын 25-ны “Ням гараг”-т БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд “Эрүүл мэндийн үнэгүй үзлэг, оношлогоо” хийлгэхээр Кореа их сургуулийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулав. Эхний ээлжийн 40 иргэнийг бүртгэлд хамруулаад байна. Иргэд, байгууллагаас хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдүүлэхээр танхимаар болон утсаар нийт 365 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлсний дагуу 2018 оны 2-р сарын 20-ноос 3 дугаар сарын 20-ны өдрүүдэд БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн албатай болон ажил олгогч эздүүд, холбогдох бусад байгууллагуудтай харилцаж, харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>БНСУ-ын “Самсунг” даатгалын газраас гэрээт ажилчидтай холбоотойгоор оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгал, гэнэтийн ослын даатгал, үйлдвэрийн ослын даатгал зэрэг нийт 131,749,771 сая вонныг иргэдэд олгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав.</p> <p>Төвийн мэргэжилтнүүдийн цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах үүднээс цаг бүртгэлийг тогтмол хөтлөн баталгаажуулж, ажлын байрны цаг ашиглалтыг зүй зохистой хэрэгжүүлж байна. ХНХҮТ-ийн ажилчид хуваарийн дагуу Ням гариг бүр ажиллаж иргэдэд үйлчилж байна.</p> <p>БНСУ-ын Пусан хотод зохион байгуулсан “Амралтын өдөр ажиллаж, иргэдэд үйлчилгээ үзүүлэх” Консулын газрын нээлттэй хаалганы өдөрлөгт 4 мэргэжилтний бүрэлдхүүнтэй оролцож, нийгмийн даатгал болон хөдөлмөрийн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. Нийт 100 гаруй иргэд хандсанаас албан ёсоор 66 иргэн бүртгүүлэн мэдээлэл, зөвлөгөө авсан болно.</p> <p>Агуулахын эмх цэгцийг сайжруулан, хөрөнгө материалыг төрөлжүүлэн хурааж, актлах, данснаас хасах хөрөнгийг ангилан төрөлжүүлэн балансад тусгалаа.</p>	

		<p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>2018 оны 3 дугаар сарын 25-ны “Ням гараг”-т Кореа их сургуулийн эмнэлэгтэй хамтран БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд “Эрүүл мэндийн үнэгүй үзлэг, оношлогоо” хийлгэж, 48 иргэнд дүрс оношлогоо, шүдний үзлэг эмчилгээ, уламжлалтын эмчийн зүү эмчилгээ болон дотрын эмчийн үзлэгээр 78 иргэнд үйлчилгээ үзүүлж үзлэг, оношлогоо, эмчилгээ хийв.</p> <p>БНСУ-ын “Самсунг” даатгалын газраас гэрээт ажилчидтай холбоотойгоор оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгал, гэнэтийн ослын даатгал, үйлдвэрийн ослын даатгалын зэрэг нийт 115,774,562 сая вонныг иргэдэд олгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав.</p> <p>2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Чонан хотын Гадаад ажилчдыг дэмжих төвийн удирдлагуудтай уулзалт хийн ажлын төлөвлөгөөгөө гаргав. 2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр БНСУ-ын Жүнбү дүүргийн Цагдаагийн ерөнхий газрын ажилтнуудтай уулзалт хийн, БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн дунд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар сургалт хийх, эргүүлийн талаар ярилцан төлөвлөгөө боловсруулж, бүртгэлийг хийв.</p>	
35	СЭРГЭЭН ЗАСАЛТ, СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	<p><u>2018 оны 1 дүгээр улирал</u></p> <p>Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, тус газраас хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний биелэлттэй танилцах, арга зүйн туслалцаа үзүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор яам, агентлаг, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалттай холбогдуулан арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Ажлын цаг ашиглалтын журмын хэрэгжилтийн хүрээнд зөрчилтэй 8 албан хаагчдад сануулах арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Тус төв нь албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан болон мэргэшүүлэх сургалт, семинарт хамруулах арга хэмжээ авч байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Японы ЖАЙКА СТАРТ төслөөс зохион байгуулсан “Портеж эрт боловсролын хөтөлбөр” 2 дахь удаагийн туршлага солилцох семинар - 2018 оны 03 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд МУИС, ШУ-ны сургуулийн ХБНГУ-ын Холбооны хөдөлмөрийн агентлагийн дээд сургуультай хамтарсан “Ажил мэргэжил судлал” мэргэжлийн магистрын сургалт - 2018 оны 02 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Ажил хөдөлмөрт бэлтгэх сургалт - 2018 оны 02 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургалт - 2018 оны 03 дугаар сарын 01, 06-ны өдрүүдэд Нинжин ТББ, Өвсний үндэс төслийн багаас зохион байгуулж буй Өрхийн эмнэлгийн эмч, сувилагчид зориулсан сургалт - Оюуны чадвар сургалтын төвийн “Илтгэл 1:0” хөтөлбөрийн 10 өдрийн сургалтанд тус тус холбогдох албан хаагчид хамрагдаад байна. Сургалтанд нийт 925000 төгрөг зарцуулсан. <p><u>2018 оны 04 дүгээр сарын байдлаар:</u></p> <p>Төвийн нийт ажилтан, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдүүлэх, аливаа ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүрэг бүхий “Ёс зүйн хороо”-г төвийн даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар 9 албан хаагчдын</p>	

	<p>бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, хорооны ажиллах журмыг баталсан.</p> <p>Мөн ажилтан, албан хаагчдыг төр болон байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үүргээ биелүүлэх үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож хэвшүүлэх зорилготой “Ёс зүйн дүрэм”-ийг төвийн даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 тушаалаар баталлаа. Төвийн www.nrc.gov.mn цахим сайтад “Ёс зүй хороо” цэс ил тод, нээлттэй ажиллаж байна.</p> <p>45 буюу түүнээс дээш хоцролттой 4 ажилтан, албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон “Ажлын цаг ашиглалтад хяналт тавих журам”, “Сахилгын шийтгэл ногдуулах журам”-ын дагуу “Сануулах арга хэмжээ” өгч ажиллалаа.</p> <p>Ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн дотоод хяналтын ажлын хүрээнд <i>2018 оны 03 дугаар сарын 29-нд хэлтэс, нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэн ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.</i> Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2018 онд нийт 195 ажил үйлчилгээ төлөвлөснөөс I улирлын байдлаар нийт 141 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, биелэлт 36.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үнэлгээний үр дүнг гаргасны үндсэн дээр ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөмжийг гаргасан. 4-р сард 14 албан хаагчийг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан болон мэргэшүүлэх сургалт семинарт хамруулаад байна.</p>	
--	---	--

ТАМГЫН ГАЗАР